

## МОНГОЛ, ЯПОНЫ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ ЯВУУЛЖ БАЙГАА ХАМТЫН АЖИЛЛАГАА

А. Буянтөгс

Монгол-Японы хамтын ажиллагаа жилээс жилд өргөн хүрээтэй хөгжиж байна. Хөдөө аж ахуйн салбарт манай хоёр орон хамтын ажиллагааны суурна тавилаа. Хоёр засгийн газрын хооронд 1994 оны 3-р сард «Мастер-план» судалгааны ажлын талаар гэрээ байгуулав. Энэ судалгаанд Монгол улсын төв хэсэгт орших Төв-Сэлэнгэ, Булган, Өвөрхангай аймаг, Дархан уул, Орхон 6 аймаг, Улаанбаатар хот (нийт талбай 235000 кв км) орсон.

Гол зорилго нь хөдөө аж ахуй ба хөдөөгийн тосгоныг иж бүрэн хөгжүүлэх, шинэ техник технологи шилжүүлэхэд оршино.

Судалгаанд хамрагдсан газрын тариалангийн талбай нь улсын 65 хувь, үр тарианы нийт үйлдвэрлэлийн 74 хувь, хүнсний ногооны нийт үйлдвэрлэлийн 80 хувийг эзэлж байна. Энэ нь Монгол улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн гол бүс нь болж байна. Малын тоо нь улсын 23 хувь орчимд хүрч байна. Мал аж ахуйн талаар тариалангийн аж ахуй шиг өндөр биш боловч цагаан идээний үйлдвэрлэл, гахайн аж ахуй, шувууны аж ахуйн зэргийн эрчимжсэн мал аж ахуйн нь тус бүсд төвлөрнө. Тус бүс бол хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах зориулалт бүхий их хэмжээний барилга байгууламжтай, улсын хүн амын 50 хувь орчим суудаг, зам харилцаа, холбоо, эрчим хүчний хангамж сайтай гэж тооцож үзээд энэ бүс нутгийг сонгож авчээ. Энэ судалгааны дагуу 2010 онд хүнсний хэрэгцээний хэтийн төлөв гаргасан.

1. Хүн ам 3000 хүн (тус бүсэд: 1,500 мянган хүн)
2. Насанд хүрсэн нэг хүнд ногдох дундаж калори: 3,140 К/кал
3. Хүнсний хэрэгцээ;
  1. Улаан буудай 314 мянган тонн (тус бүсэд 156 мянган тонн)
  2. Төмс 192 мянган тонн (тус бүсэд 98 мянган тонн)
  3. Хүнсний ногоо 191 мянган тонн (тус бүсэд 98 мянган тонн)
  4. Мах 255 мянган тонн (тус бүсэд 115 мянган тонн)
  5. Сүү 762 мянган тонн (тус бүсэд 321 мянган тонн)
  6. Өндөг 158 сая ширхэг (тус бүсэд 99 сая ширхэг)-т хүргэхээр тус тус тооцжээ.

Тариалах газар ихтэй Сэлэнгэ, Төв, Өвөрхангайн хойт хэсэгт үр тарианы аж ахуйг хөгжүүлнэ. Үүний тулд үр тарианы аж ахуйн салбарт нийтлэг шинжтэй гол арга хэмжээнүүдийг авна. Үүнд:

1. Атаржуулсан талбай болон сул тоног төхөөрөмжийг ашиглуулах;

А. Буянтөгс. Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, дэд доктор.

2. Дарханы ургамал тариалангийн хүрээлэнгийн тоног төхөөрөмжийг сайжруулах;

3. Салхинаас хамгаалах арга хэмжээ авах;

4. Техник технологийг өргөн нэвтрүүлэх зэрэг болно. Мөн төсөл хэрэгжүүлэх газар болгоны хувьд тусгай арга хэмжээ авна.

Хүн амд шинэ ургацыг тогтвортой нийлүүлэхийн тулд Дархан, Улаанбаатар зэрэг том хотын орчимд барааны баазыг бий болгоно. Тэнд усалгаатайгаар (хүлэмжийн аргаар бас) ногоо, жимс, ургуулна. Үүнд:

1. Усалгаатай тоног төхөөрөмжийг сэргээх, усалгааны систем, тоног төхөөрөмжийг өөрчлөн бэлтгэх;

2. Жижиг дунд усалгааг хөгжүүлэхэд загвар газарт туршилт хийх;

Чихэр, ургамлын тосоор хангахын тулд чихрийн манжин, тосны ургамал тариалж чихэрлэг, тослог ургамлын үйлдвэрлэлийг шинээр зохион байгуулж, үйлдвэрлэлийг сайжруулна. Үр тариаг хадгалах, эргэлтэд оруулах, боловсруулахтай холбоотой байгууллагуудыг бэлтгэх, системтэй бэхжүүлэх, тухайн газар нутагт зохистойгоор байршуулах;

Үйлдвэрлэлийн нэгж ба хадгалах, боловсруулах байгууллагуудын хоорондох харилцаа замыг сайжруулах;

Мал аж ахуйн салбартай хамт малын тэжээл нийлүүлэх системийг зохион байгуулах. Тус бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, Энэ нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Арвайхээр гэх мэтийн том хот болон аймгийн төвийн дүүрэг газарт, хуучин сангийн аж ахуйн өмч хөрөнгийг ашиглан, сүүний үйлдвэрлэл гахай шувуу мэтийн нийлүүлэлтийн аж ахуйг хөгжүүлэх арга хэмжээ авна.

Булган, Овөрхангай аймгийн өмнө хэсэгт өвс бэлчээрийн нөхцөлд тохируулан малын үр удмыг сайжруулах гэх мэтийн аргаар үхэр, адуу, хонь, ямаа болон тэмээний уламжлалт нүүдлийн мал аж ахуйгаар гол болгож мал аж ахуйн тасралтгүй үйлдвэрлэх систем болон үйлдвэрлэлийн хүч чадлыг бэхжүүлэх. Үүнд:

1. Худаг гэх зэргийн уух болон амьдралын хэрэгцээт усыг хангах тоног төхөөрөмжийг аль болохоор шуурхай бий болгох.

2. Өвөлжилтийн малын тэжээлийг нөөцөлж хадгалах арга хэмжээ авах.

3. «Туувар»-ын системтэй холбогдсон тоног төхөөрөмж бэлтгэх.

4. Малчдын хамтарсан зохион байгуулалтыг хөгжүүлж бэхжүүлэх.

5. Орон нутагт дунд болон бага оврын боловсруулах тоног төхөөрөмж бэлтгэх зэрэг болно.

Бас орон нутаг дахь байгууллагуудыг бэлтгэж, тухайн орон нутгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээ авна.

Япон улсын буцалтгүй тусламжаар хэрэгжих энэхүү төсөл нь өнөө үед манай улсын төр засгаас ошлон анхаарч буй хүнсний хангамж, нөөцийг нэмэгдүүлэх зорилгыг хэрэгжүүлэхээс гадна цаашид хөрш хоёр орнууд руу хүнсний бүтээгдэхүүнийг экспортлох чадварыг бий болгох нь чухал ач холбогдолтой юм.